



ᠰᠤᠬᠤᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠲᠦᠳᠦᠷᠭᠢᠨ ᠡᠳᠢᠶ᠋ᠨ ᠵᠠᠰᠠᠭ, ᠨᠢᠶᠭᠮᠢᠶ᠋ᠨ ᠪᠠᠶᠳᠠᠯ

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЭДИЙН
ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

ИНФОГРАФИК
2022 I-XI



ХҮН АМ

2022 оны эхний 11 сард Сүхбаатар дүүрэгт **2135** хүүхэд шинээр мэндэлж, 1000 хүнд ногдох төрөлт **14.8** болж, өмнөх оны мөн үеийнхээс **6.5** нэгжээр буурчээ.

1000 ХҮНД НОГДОХ



Төрөлт **14.8**

Нас баралт **5.2**

Ердийн цэвэр өсөлт **9.6**

Оны эхний 11 сарын байдлаар нас баралт **754** бүртгэгдэж, 2021 оны мөн үеэс **119-өөр (13.6%)** буурсан бол өмнөх сараас **73-аар (10.7%)** нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ЕРДИЙН ЦЭВЭР ӨСӨЛТ, сүүлийн 5 жилийн эхний 11 сард

9.3

Хамгийн бага

Хамгийн их

14.3

Ердийн цэвэр өсөлт: Хүн амын тооны өсөлт, бууралтыг харуулна.



ТӨРСӨН ХҮҮХЭД

2021
I-XI



2022
I-XI

2224

2135 ↓

Дүүргийн хэмжээнд 2022 оны эхний 11 сард **2121** эх амаржин, **2135** хүүхэд шинээр мэндэлж, **13** амьгүй төрөлт бүртгэгдсэн байна.

Эх, хүүхдийн эндэгдлийн **32** тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **1** тохиолдлоор (**3.2%**) нэмэгдсэн сөрөг үзүүлэлттэй байна.

ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

23↑ 0-1 хүртэлх насны

1-5 хүртэлх насны 9↑

- Эхийн эндэгдэл

ЭХИЙН ТӨРӨЛТ

9↑ Гэрийн төрөлт

Хяналтгүй төрөлт 11↑

Өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо **3.9** хувиар буурчээ. Гэрийн төрөлтийн **9**, хяналтгүй төрөлтийн мөн **11** тохиолдол бүртгэгджээ.



ЭРҮҮЛ МЭНД

НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ

2021 I-XI	Халдварт өвчин	228	
	Цочмог халдварт өвчин	36468	36696
2022 I-XI	Халдварт өвчин	262	13258
	Цочмог халдварт өвчин	12996	

2022 оны эхний 11 сарын байдлаар 10.0 мянган хүн тутмын 897 нь цочмог, 16 нь халдварт өвчнөөр өвчилсөн байна.

ХАЛДВАРТ ӨВЧИН - 262



ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН - 12996



Коронавирус халдварын тохиолдол 2022 оны 1 сард 8765, 2 сард 2641, 3 сард 651, 6 сард 360, мөн 9 сард 205 тохиолдол бүртгэгдсэн сөрөг үзүүлэлттэй байсан бол 4,5,7,8,10,11 дүгээр саруудад бүртгэгдээгүй эерэг үзүүлэлттэй байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ



Ehalamj системээр 2022 оны 11 сард олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийн мэдээ

	2022 I	2022 XI
Халамжийн тэтгэвэр	1 815 хүн 522.2 сая төг	1 907 хүн 535.6 сая төг
Алдарт эх одонгийн мөнгө	7 939 хүн 971 сая төг	2 хүн 0.2 сая төг
Алдар цолтон ахмад настан хөнгөлөлт	5 хүн 1.2 сая төг	16 хүн 3.6 сая төг
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	51 525 хүн 5 152.5 сая төг	52 978 хүн 5 297.8 сая төг
Бусад тэтгэмж	17 516 хүн 1 340.9 сая төг	12 263 хүн 1 058.8 сая төг



НИЙГМИЙН ДААТГАЛ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН

	2021 I-XI	2022 I-XI
ОРЛОГО, тэрбум төгрөг	327.2*	365.4 ↑
ЗАРЛАГА, тэрбум төгрөг	134.0	165.9 ↑
ОЛГОСОН ТЭТГЭВЭР	20.4	21.4 ↑
Тэтгэвэр авагчийн тоо, мянган хүн		
Олгосон тэтгэвэр, тэрбум төгрөг	106.4	138.3 ↑
ОЛГОСОН ТЭТГЭМЖ	31.7	30.1 ↓
Хамрагдсан хүн, мянган хүн		
Олгосон тэтгэмж, тэрбум төгрөг	27.6	27.6




БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

2021 I-XI 599

2022 I-XI 426↓



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны ангиллаар, дүнд эзлэх хувиар, 2022 I-XI



Дүүргийн ХХҮХ-т бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 11 сарын эцэст 426 болж, өмнөх оны мөн үеэс 173-аар (28.9%) буурсан үзүүлэлттэй байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдээс оны эхний 11 сард 585 иргэн ажилд зуучлагдан орсон нь өмнөх сараас 457-гоор (43.9%) нэмэгджээ.



БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

2021 I-XI

2 070



2022 I-XI

3 572↑

1-р хэлтэс

2-р хэлтэс

(1-9 дүгээр хороо)

(10-20 дугаар хороо)

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2 257 (63.2%)

Бүртгэгдсэн гэмт хэрэг 1 315 (36.8%)

Илрүүлэлт 46.3%

Илрүүлэлт 55.1%

Дүүргийн хэмжээнд 2022 оны эхний 11 сард 1-р хэлтэст 2257, 2-р хэлтэст 1315, нийт 3572 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеийнхээс 1502 хэргээр 72.6 хувиар өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн илрүүлэлт дүүргийн хэмжээнд 49.8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.5 нэгж хувиар нэмэгджээ.

Мөн зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл өссөн дүнгээр 16164 бүртгэгдсэн байна.



БҮРТГЭГДСЭН ТҮЙМЭР, ҮЕР, УС

БҮРТГЭГДСЭН ГАЛ ТҮЙМЭР, төрлөөр

2021 I-XI

2022 I-XI

154

135↓

Объектын

13

24↑

Хогны

15

68↑

Өнжмөл шар өвсний

БҮРТГЭГДСЭН ҮЕР, УСНЫ ДУУДЛАГА

16

1↓

Үер ус, халиа дошин

2022 оны эхний 11 сард дүүргийн хэмжээнд объектын гал түймрийн 135, хогны 24, өнжмөл шар өвс шатсан 68, халиа дошны 1, нийт 228 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 30-аар буюу 15.2% өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн гал түймрийн өсөлтөд өнжмөл шар өвс шатсан дуудлага 53-аар буюу 4.5 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО, сая төгрөг



Төлөвлөгөө 265 737.9

Гүйцэтгэл 245 653.9

Биелэлт 92.4%

2022 оны эхний 11 сард дүүргийн төсөвт 245.6 тэрбум төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 92.4 хувиар биелжээ. Төвлөрсөн орлогын 96.0 хувийг урсгал орлого, 4.0 хувийг төсвийн урсгал санхүүжилтийн орлого эзэлж байна.

Харин урсгал орлогын 99.1 хувийг татварын орлого, 0.9 хувийг татварын бус орлого бүрдүүлжээ.

ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА, сая төгрөг



Төлөвлөгөө 262 029.8

Гүйцэтгэл 241 507.2

Биелэлт 92.2%


Оны эхний 11 сарын байдлаар төвлөрсөн орлогын 98.3%-ийг урсгал зардалд зарцуулаад байна. Урсгал зардлын дийлэнх буюу 99.7%-ийг бараа үйлчилгээний, 0.3%-ийг бусад зардал эзэлж байна.

Бараа үйлчилгээний зардлын дийлэнх буюу 82.7%-ийг нийслэлд төвлөрүүлсэн орлогод, 2.3%-ийг цалин хөлс нэмэгдэл урамшуулалд, 0.3%-ийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд, 14.7%-ийг бараа үйлчилгээний бусад зардалд тус тус зарцуулжээ.



АЖ ҮЙЛДВЭР (*урьдчилсан гүйцэтгэл)

2021 I-XI Нийт үйлдвэрлэл 3 352.6 тэрбум төгрөг
Нийт борлуулалт 7 243.0 тэрбум төгрөг



2022 I-XI Нийт үйлдвэрлэл 3 276.2* тэрбум төгрөг
Нийт борлуулалт 10 049.4* тэрбум төгрөг

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар

2021 I-XI

2022 I-XI

УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ (16.4%↑)

2 642.2 тэрбум төгрөг



3 074.8*↑ тэрбум төгрөг

БОЛОВСРУУЛАХ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ (71.7%↓)


706.4 тэрбум төгрөг



199.9*↓ тэрбум төгрөг

ЦАХИЛГААН, ДУЛААН, ЭРЧИМ ХҮЧ, УСАН ХАНГАМЖ ҮЙЛДВЭРЛЭЛ (62.5%↓)

4.0 тэрбум төгрөг



1.5*↓ тэрбум төгрөг



ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ




Цэвэрлэсэн зам талбай 436.8 мян.м2

Зарцуулсан хөрөнгө 2 728.4 сая төгрөг

ТЭЭВЭРЛЭСЭН ХОГ, байршлаар, 2022 I-XI

33 889.8 ТН Орон сууцнаас



Гэр хорооллоос 19 404.6 ТН

11 743.3 ТН Зуслангаас



2022 оны эхний 11 сард дүүргийн хэмжээнд 65.0 мянган тонн хог тээвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 10.3 мянган тонноор буюу 18.8 хувиар өсжээ.

Тээвэрлэсэн хогны 52.1 хувийг орон сууцнаас, 29.8 хувийг гэр хорооллоос, 18.1 хувийг зуслангаас тус тус тээвэрлэжээ.

Хог тээвэрлэлтэд нийт 2728.4 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 683.6 сая төгрөгөөр (33.4%) өссөн үзүүлэлттэй байна.

